

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдал

Олон улсын сэтгүүлчдийн холбооны тодорхойлсноор “Хэвлэлийн эрх чөлөө гэж хөндлөнгийн оролцоогүй, аливаа дарамт шахалтгүй байх”-ыг хэлнэ. “Хараат бус хэвлэл гэж засгийн газар, улс төр, эдийн засгийн хяналт, мөн материал, үйлдвэрлэл, түгээлтийн дэд бүтцээс хараат бус байхыг хэлнэ” хэмээн ЮНЕСКО, Олон улсын сэтгүүлчдийн холбооноос хамтран баталсан Уэндхүекийн зарчимд тунхагласан байдаг.

Хэвлэлийн эрх чөлөө бол хүний эрхийн суурь зарчмын салшгүй хэсэг юм. Чөлөөт, хараат бус хэвлэл бол ардчилсан нийгмийн бодит шаардлага билээ.

Монгол иргэдийн мэдээлэлтэй байх эрх Үндсэн Хуулиар баталгаажсан. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө хэдий хэр зөрчигдөнө, тэр хэмжээгээр хүний эрх зөрчигдөнө. Чөлөөт хэвлэлтэй байх иргэний эрхийг амьдралд бодитой хэрэгжүүлдэг хүмүүс нь сэтгүүлчид юм. Сэтгүүлчдийн эрх зөрчигдөх тусам олон нийтийн улс оронд болж буй үйл явдлын талаар үнэн бодитой мэдээлэлтэй байх боломж хязгаарлагдаж, төөрөгдөлд хүргэдэг. Иймээс сэтгүүлч хараат бус, мэргэжлийн эрхээ эдлэх боломжтой байх ёстой.

Манай улсад хэвлэл мэдээллийн эрх чөлөө, сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх хуулиар баталгаажсан байдаг. Гэсэн хэдий ч амьдрал дээр сэтгүүлчдийн эрх зөрчигдсөөр байгаа юм. Сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн гол зөрчил цензурээр дамжин илэрдэг. Цензурыг манайд 1998 оны Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар хориглосон байдаг. Гэтэл хэрэг дээрээ бүх төрлийн цензур бодитой хэвээр байна.

Төрийн цензур. Энэ нь хуулиар дамжин илэрдэг. Хуулиар төр ХМХ эзэмшихийг хориглосон нь том алхам юм. Гэвч сэтгүүлчийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, түгээх мэргэжлийн үйл ажиллагааг янз бүрийн хуулиар хязгаарласан байдаг. 2007 онд манай хуульчдийн хийсэн судалгаагаар 360 шахам хуулийн 30 хувьд л төрийн байгууллагын мэдээлэл нээлттэй байх хэм хэмжээг заасан. Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай гэх мэт мэдээлэл авахыг хязгаарласан хууль дийлэнх байдаг. Өргөн нэвтрүүлгийн хэрэгслийн тусгай зөвшөөрлийг төрийн байгууллага олгодог нь цензурын нэг хэлбэр юм. Төрийн цензур төрийн байгууллага, төрийн албан тушаалтан, эрх мэдэлтнүүдийн зүгээс нэр төр, алдар хүнд, гүтгэлэг, доромжлолтой холбоотойгоор нэр төрөө сэргээлгэх хэрэг, нууц эрх сурвалжаа илчлэхийг албадах, гэрчээр дуудан байцаах, шүүхээр далайлгах, баривчлах, хорихоор сүрдүүлэх зэрэг шүүх, цагдаа, тагнуул гэх мэт хүчний байгууллагын дарамтаар дамжин хүчтэй илэрч байна. Төрийн цензур ямар хүчтэйг 7 сарын нэгний үйл явдал харуулсан. МҮОНТ-ийн мэдээллийн эх сурвалжийн талаас дийлэнх хувийг засгийн газар эзэлж байв.

Улс төрийн цензур. ХМХ-ийн өмчлөлөөр дамжин хүчтэй илэрч байна. Төрийн өндөр албан тушаалтан, улс төрчдийн эзэмшиж буй, хөрөнгө оруулсан ХМХ-ийн нэр нийтэд ил тод бус. ХМХ нэг хүний гарт төвлөрч, олон ургальч хэвлэл мэдээллийг хязгаарлах үзэгдэл бий болж байна.

Эдийн засгийн цензур. Төрөөс эдийн засгийн шууд цензур тогтоох нь ховор. НӨТ-ийн хөнгөлөлт зэрэг нааштай алхам хийсэн. Гол төлөв реклам нийлүүлэгчдийн зүгээс хүчтэй цензур байдаг. Сонин сэтгүүлийн хувьд Түгээлтийн систем,

Захиргааны цензур. Эрх зүйн хэм хэмжээний акт, гэрээ, байгууллагын дүрэм журмаар дамжин илэрдэг. Саяхны жишээ нь Цагдаагийн ерөнхий газрын ХМХ-тэй хамтран ажиллах гэрээ юм. Энэ гэрээнд зааснаар ХМХ “Жагсаал, цуглааны үеэр нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсвэл түүнийг тараах, намжаах зорилгоор цагдаагийн байгууллагатай хамтран ухуулга сурталчилгаа хийх” ёстой ажээ. Сэтгүүлчид ухуулга сурталчилгаа хийх үүрэггүй, тэдний олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг нь гагцхүү үнэнийг хэлэхэд оршдог. ЦЕГ зөвхөн гэрээтэй ХМХ-ийн сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах юм байна.

Редакцийн цензур. ХМХ-ийн удирдлагаар дамжин эздийн зүгээс хүчтэй илэрдэг

Өөрийн цензур. Янз бүрийн шалтгаанаар сэтгүүлч айдас хүйтэст автаж, өөрийгөө хянадаг хэлбэр. Сэтгүүлчдийг утсаар дарамтлах, заналхийлэх, эрүүл мэндэд нь халдах, доромжлох, албан тушаалаар далайлгах, ажлын багаж хэрэгсэлд халдах, хураан авах зэрэг

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага ННФ, ННХ-гийн Хэвлэл мэдээллийн бүсийн хөтөлбөрийн дэмжлэгээр 2005 оны 10 сараас сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчилд мониторинг хийж байгаа билээ.

Сэтгүүлчдийн эрхийн зөрчлийн хэлбэрийг оноор нь харъя.

Зөрчлийн хэлбэр	2005 оны 10 сараас 2006	2007	2008	Нийт
Бие эрхтэн, эрүүл мэндэд халдсан	3	3	6	12
Сүрдүүлсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, гэр бүлийн хүнийг дарамталсан	16	7	23	46
Мэдээлэл өгөхөөс татгалзсан	8	10	13	31
Ажлын багаж хэрэгсэлд халдсан	3	3	2	8
Шүүх, хүчний байгууллагын дарамт	2	8	5	15
Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан	3	1	5	9
Нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсвэл хориглохыг завдсан	2	1	3	6
Эрүүгийн хэрэг үүсгэсэн, түр саатуулагдсан, хоригдсон	4	4	2	10
Нийт	41	37	59	137

2008 онд хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн эсрэг 59 зөрчил бүртгэгдсэн нь түрүү оныхтой харьцуулахад 22 тохиолдлоор илүү байна. 2008 онд сэтгүүлчдийн эсрэг зөрчлийн 60 хувийг төрийн албан тушаалтан үйлджээ. Үүнээс долоон хэрэг нь сонгуулийн төлбөрт материалаас болж үүссэн байна.

Эрүүл мэндэд халдсан сэтгүүлчдийн дунд хүчиндүүлсэн хоёр сэтгүүлч бүртгэгдсэн.

Дээр дурдсан зөрчлийн бүртгэлийг бид бүрэн гэж үзэхгүй байна. Учир нь зарим сэтгүүлч дахин дарамт шахалтад өртөхгүйн тулд бидэнд мэдээлэхээс айдаг, эсвэл бүртгүүлсэн ч өөрийнх нь тухай мэдээллийг нийтэд ил тод болгохыг хүсдэггүй. 2008 онд гэхэд 12 сэтгүүлч зөрчлийнхөө тухай мэдээлсэн ч нийтэд зарлахыг хүсээгүй юм. Дээрх хүснэгтэд бид зөвхөн нотлогдсон, баталгаажсан зөрчлийг харуулсан юм. Бүртгэгдэж, архивт орсон зөрчлийн мэдээлэл мөн нэлээд байгаа юм.

Сэтгүүлчдийг онцгой эрхгүй, онц үүрэгтэй гэж үздэг. Нууц эх сурвалж буюу мэдээлэгчээ хамгаалах нь сэтгүүлчийн онцгой үүрэг юм.

2007 онд “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагаас нууц эх сурвалжтай харилцах хэлбэр, нууц эх сурвалжаа хамгаалахад тохиолдох саад бэрхшээл, түүнд эрүүгийн хуулийн гүтгэх, доромжлох заалтууд хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх зорилгоор мэдээ, нийгэм, улс төрийн чиглэлээр идэвхтэй ажилладаг 203 сэтгүүлчийг хамарсан судалгаа хийсэн юм. Судалгаанд 72 эрэгтэй, 131 эмэгтэй сэтгүүлч хамрагдсан. Судалгаанд хамрагдсан 203 сэтгүүлчийн 13 хувь нь нууц эх сурвалжийг тогтмол ашигладаг, 40 хувь нь нийтлэл/нэвтрүүлгийнхээ ихэнх хувьд нь ашигладаг, 43 хувь нь шаардлагатай үед, цөөн тохиолдолд ашигладаг ажээ. Харин сэтгүүлчдийн 4 хувь нь нууц эх сурвалжтай харьцдаггүй юм байна. Улаанбаатар хотын сэтгүүлчид хөдөө орон нутгийнхнийг бодвол нууц эх сурвалж ашиглалтаараа бараг 2 дахин их байна. ХМХ-ийн хэлбэрээр авч үзвэл, сонины сэтгүүлчид бусад ХМХ-ийн сэтгүүлчдийг бодвол нууц эх сурвалжид түлхүү тулгуурладаг ажээ. Монголд эрэгтэй сэтгүүлчид эмэгтэйг бодвол нууц эх сурвалжийг илүү ашигладаг байна. Мөн хэвлэл мэдээллийн салбарт 2-3 жил ажиллаж буй сэтгүүлчид нууц эх сурвалж ашиглах нь түгээмэл байна.

Нууц эх сурвалж ашигладаг 195 сэтгүүлчийн 45,6 хувь нь мэдээлэл ямар ч тохиолдолд найдвартай санагддаг, 43,1 хувь нь өөр аргаар мэдээлэл олж авах боломжгүй үед ашигладаг ажээ. Нууц эх сурвалж тогтмол болон их ашигладаг сэтгүүлчдийн хувьд эх сурвалжийн найдвартай байдал нь илүү чухал, ач холбогдолтой бол цөөн ашигладаг сэтгүүлчдийн хувьд мэдээлэл олж авах боломжгүй байдал нь нууц эх сурвалжийг ашиглах шалтгаан болж байна.

195 сэтгүүлчийн 53 хувь нь байнгын харилцаатай, нууц эх сурвалжтай байна.

Мөн нууц эх сурвалж ашиглалтын түвшин, хэвлэл мэдээллийн салбарт ажилласан жил өсөх тутам байнгын харилцаатай нууц эх сурвалжаас мэдээлэл авах нь нэмэгдэж байна. Нууц эх сурвалж ашигладаг 195 сэтгүүлчийн 62 хувь нь тэдний өгсөн мэдээлэлд итгэлтэй байдаг хэдий ч үргэлж нэмэлт эх сурвалжуудаар шалгаж баталгаажуулдаг, харин 9 хувь нь нууц эх сурвалжийнхаа өгсөн мэдээлэлд бүрэн итгэлтэй байдаг учир шалгадаггүй, 20 хувь нь олон нийтийн эрх ашигт

нийцсэн мэдээллийг шууд нийтэд дэлгэдэг гэжээ. Харин 4 хувь нь нууц эх сурвалжийнхаа өгсөн мэдээлэлд итгэдэггүй ч түүнийг ашиглах шаардлага гардаг гэсэн байна.

195 сэтгүүлчдийн 70 хувь нь нууц эх сурвалждаа амлалт өгдөггүй юм байна. Тэдний 52.3 хувь нь итгэлцлийн үндсэн дээр эх сурвалжтайгаа харилцдаг бол 12.8 хувь нь гэрээ хэлэлцээ хийдэг ажээ.

Тогтмол нууц эх сурвалжид үндэслэдэг сэтгүүлчдийн 69 хувь тухайн мэдээллийг илчлэх зорилгыг нь үргэлж асуудаг бол, 31 хувь нь асуудаггүй гэжээ.

Сэтгүүлчдийн 41 хувь нь эх сурвалжаа хамгаалж, илчлэхгүй байж чадна гэдэгтээ итгэлгүй байна. Энэ нь Улаанбаатар хотын 174 сэтгүүлчийн 37 хувь, хөдөө орон нутгийн сэтгүүлчдийн 71 хувийг хамарч байгаа нь ялангуяа орон нутагт сэтгүүлчдэд ирэх дарамт, шахалт их байгааг нотолж байна.

Сэтгүүлчдийн нууц эх сурвалжийн илчлэгдсэн тохиолдолд 56.4 хувь нь ажилгүй болох, 39 хувь нь амь нас, эрүүл мэндээрээ хохирох, 32.8 хувь нь нэр хүндээ алдах, 16.4 хувь нь ар гэрийнхэндээ эрсдэл учруулах, 7.7 хувь нь эд хөрөнгийн хохирол амсахаас айж эмээдэг байна. Судалгаанд хамрагдсан сэтгүүлчдийн 38 хувь нь нууц эх сурвалжаа илчлэх албадлагад өртөж байжээ. Энэ нь Улаанбаатар хотод 37 хувь, орон нутагт 48 хувьтай байна. Тэдгээр 74 сэтгүүлчийн 39.4 хувьд цагдаа, 29.7 хувьд шүүх, 43.2 хувьд улс төрч, төрийн байгууллага, 10 хувьд тагнуулын ерөнхий газар, 35.2 хувьд хувь хүн, улс төрийн нам, хүчин нууц эх сурвалжаа илчлэхийг шаардаж байжээ. Мөн 6.8 хувьд ийм шаардлага төрийн бус байгууллага, олон улсын байгууллагаас тавьсан байна.

Эдгээр сэтгүүлчийн 23 хувь, өөрөөр хэлбэл 45 сэтгүүлч, тодруулбал 4 сэтгүүлч тутмын нэг нь мэдээллийнхээ нууц эх сурвалжийг илчилж байжээ. Тэдгээрийн ихэнх нь буюу 40.9 хувьд шүүхийн шаардлагаар нууц эх сурвалжаа илчилжээ. Үүнийхээ шалтгааныг тэд аюулгүй байдлаа хангах (28.9%), шүүх байгууллагын шахалт, сүрдүүлэгт автсан (24.4%), ажлаасаа халагдахгүйн тулд (20%), мөн цөөн хувь нь шүүх, хүчний байгууллагын эх сурвалжийг нууцлах амлалтад итгэсэн, шоронд хоригдох, ял эдлэхгүйн тулд гэх зэргээр тайлбарласан байна.

Нууц эх сурвалжийн өгсөн мэдээллээс шалтгаалан сэтгүүлчдийн 29 хувь эрүүгийн хэрэг, иргэний маргаанд холбогдож байжээ.

Сэтгүүлчдийг нууц эх сурвалжийнхаа өгсөн мэдээлэлтэй холбогдуулан шүүх хуралд гэрчээр дууддаг практик байгаа нь судалгаагаар нотлогдов. Сэтгүүлчийн 15 хувь нь буюу 31 сэтгүүлч гэрчээр дуудагджээ.

Хэвлэлийн эх чөлөөг улам гүнзгийрүүлэн баталгаажуулах, сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийг хамгаалахын тулд зайлшгүй хийх зүйлийг дор дурдав. Үүнд:

Хууль эрх зүйн чиглэлээр:

1. Хэвлэлийн эрх чөлөөг хязгаарласан хууль, хуулийн заалтыг өөрчлөх
2. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг нэн даруй батлах
3. Төрийн, байгууллагын нууцын тухай, мөн зарим хуульд мэдээллийг ил тод болгох чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах
4. Сэтгүүлчийн нууц эх сурвалжаа хамгаалах тухай хууль батлах
5. ХМХ-ийн өмчлөлийг ил тод болгох, төвлөрлийг хязгаарлах зэрэг хуулийг шинээр батлах
6. ХМХ-ийн нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэхийн тулд сонин хэвлэл, өргөн нэвтрүүлгийн хэрэгслийн тухай хууль батлах
7. Сонгуулийн хуулиудын хэвлэл мэдээлэлтэй холбоотой зүйл заалтыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн өөрчлөх
8. Эрүүгийн хуулийн гүтгэлэг, доромжлолтой холбоотой заалтыг эргэн хянаж, жирийн иргэн, эрх мэдэлтнүүдэд ялгавартай хандах жишиг тогтоох
9. Дээрх зүйл заалтын тухай Дээд шүүхийн тайлбарыг эргэн үзэж, олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх
10. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хориг тавихыг гэмт хэрэг гэж үзсэн Эрүүгийн хуулийн 139-р зүйлийг илүү нарийвчилж, тодорхой болгон, хэрэглэх боломжтой болгох

Хэвлэл мэдээллийн өөрийн хариуцлага, зохицуулалтын чиглэлээр:

1. Мэргэжлийн эвлэл холбоод, ХМХ хамтран хэвлэл мэдээлэл, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг нарийвчлан боловсруулж, мөрдүүлэх
2. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тогтолцоо байгуулж, хөгжүүлэх
3. Хэвлэл мэдээллийн манаач буюу олон нийтийн хяналтын сайн дурын байгууллагын үүсгэл санаачилгыг дэмжих

Сургалт, сурталчилгааны чиглэлээр:

1. Хэвлэлийн эрх чөлөө, иргэдийн үнэн мэдээлэлтэй байх хууль ёсны эрх ашгийн тухай шүүгчдийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх
2. Мэргэжлийн ёс зүй, нийгмийн өмнө хүлээх хариуцлагын тухай сэтгүүлчдийн мэдлэгийг дээшлүүлэх
3. Төрийн албан хаагч, олон нийт, сэтгүүлчдэд хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой хууль тогтоомжийг таниулах, сурталчлах ажлыг эхлүүлж, эрчимжүүлэх
4. Хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой хуулийн хэрэгжилтэд хяналт тавих

**Х. Наранжаргал, “Глоб Интернэшнл”
төрийн бус байгууллагын тэргүүн**

2009.10.23